



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Байгууллагын тэмдэг түших  
ажилтныг түр томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ын 6.6 дахь хэсэг, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Эрдэнэбилэгийн Нарантунгалагийн ээлжийн амралттай байх хугацаанд Иргэний нисэхийн үндэсний төвийн тэмдэг түших ажилтнаар Захиргаа, хүний нөөцийн газрын ахлах мэргэжилтэн Дагвын Ариунтуяаг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс түр томилсугай.

2.Байгууллагын тэмдгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу түшиж, хадгалалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг ахлах мэргэжилтэн (Д.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (З.Туяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН